



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/32

Алтай хот

Чандмань сумын Соёлын төвд
урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын яамнаас зарласан уралдаанд амжилттай оролцож баруун бүсийн "Жишиг соёлын төв"-өөр шалгарсан Чандмань сумын Соёлын төвийг урамшуулсугай.

2.Урамшуулалд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Батзориг)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР